



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/404

Булган сум

Г Хяналт тавьж, данс бүртгэлд бүртгэх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хандив, зээл тусламж, бусад эх үүсвэрээс санхүүжих төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд зураг төсвийн дагуу хяналт тавьж, чанар болон хугацааны хяналтыг тогтмол хийж холбогдох хууль журмын дагуу ашиглалтад хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2. Хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг тодорхойлж данс бүртгэлд бүртгэж, ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга), Сумдын засаг дарга, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

